



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.12.20 № 31-1/170
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



ЛОЮУН-ЭРДЭНЭ

000234004176



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2013. 12. 18 № ХТ/2682
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 5 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235026626

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлд:

"VIII.ХЭЛЭЛЦСЭН нь: "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2023.12.15 № 09/6670
танай _____-ны № 01/8977 -т

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

115233810



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Широндрэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15100
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахым шуудан: info@mjha.gov.mn,
Цалим хуудас: www.mjha.gov.mn

2023.12.15 № 1/6335
тэнгэр 2023.12.06-ны № 01/8976

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

Монгол Улсын Засгийн газар, Бүгд
Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын
"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах
ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн
Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн
20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж
үзэв.


Б.ЭНХБАЯР



151605456
Doc. date 15.12.2023



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.12.12 № 01/9055

тантай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улс Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хавсралт: 19 хуудас.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761003072



Б.ЖАВХЛАН



С.АМАРСАЙХАН



Ч.ХҮРЭЛБААТАР



Б.БАТЦЭЦЭГ



Б.ЭНХБАЯР

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн санал, дүгнэлт, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дүгээр сарын 05-ны өдрийн 162 дугаар захирамжийг үндэслэн “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Онцгой байдлын ерөнхий газрын аврах ажиллагааны мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг сайжруулан, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

Товч танилцуулга

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Санхүүгийн хэлэлцээрийг хийж, Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаан, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлсэн болно. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 162 дугаар захирамжийг үндэслэн Санхүүгийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай

хуулийн төслийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл, олон нийтийн дунд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газар дээр зохион байгуулан, хэлэлцүүлэн хийж, саналыг авсан. Түүнчлэн, Сангийн яам болон Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулан, саналыг авсан болно.

5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:

Уг хуулийн төсөлд тусгасан "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас хэрэгжүүлэхтэй холбоотой бусад судалгааг хийсэн.

Дэлгэрэнгүй танилцуулга

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно. /Төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав/.

*“Онцгой байдлын ерөнхий газрын
агаараас аврах ангид нэмэлт сургалт
явуулах төсөл”-ийн тухай*

1. Төслийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас 2019 онд авсан 58 сая еврогийн зээлийн хөрөнгөөр “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн I шатны хүрээнд 4 нисдэг тэрэг худалдан авч, нисдэг тэрэгний дэд бүтцийг байгуулж, нисгэгч, инженерүүдийг сургалтад хамруулсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 85 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, ослын улмаас бэртэж гэмтсэн, газраар тээвэрлэх боломжгүй нөхцөлд байсан 122 хүний амь насыг аварч, анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэн, дараагийн шатны эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй хүлээлгэн өгсөн.

Монгол Улсад оруулсан хувь нэмэр, нийгмийн үр өгөөжийг өндрөөр үнэлж, Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон нь Монгол Улсад 2023 оны 05 дугаар сард хийсэн айлчлалын үеэр хоёр улсын ерөнхийлөгч нарын хамтарсан тунхаглалд дээрх төслийг үргэлжлүүлэн, төслийн II шатыг эхлүүлэхээр тогтсон. Энэ хүрээнд төслийн II шатын Санхүүгийн хэлэлцээрийг Засгийн газар, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлсэн болно. Ингэснээр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн айлчлалын үеэр Санхүүгийн хэлэлцээрт Ерөнхий сайдын 2023 оны 166 дугаар захирамжийг үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

Цаашлаад төслийн II шатын хүрээнд онцгой байдлын нисгэгч, инженер техникийн ажилтнуудыг Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний аюулгүй байдлын газар, түүний харьяа агаарын ажиллагааны бааз болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургалтын төвд сургаж дадлагажуулах, сургагч, инженер ажилтнуудыг Монгол Улсад ажиллуулах, нисдэг тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээг хийх юм.

Ингэснээр төслийн II шатын хүрээнд “Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Өдөр, шөнийн нислэгийн эрхтэй нисэх багийн дарга 7, хамтран нисгэгч 5 тус тус бэлтгэгдэж, Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс эрх авсан байна.
- Инженер техникийн бүрэлдэхүүний техник үйлчилгээ хийх чадвар дээшилж, их бие, хөдөлгүүрийн инженер, техникийн ажилтнууд II шатны сургалтад хамрагдан ур чадвар нэмэгдсэн байна.
- Инженерийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн бэлтгэгдэж нисдэг тэрэгний ашиглалтын төлөвлөлтийг боловсруулах, сэлбэг хэрэгслийг захиалах, техник

үйлчилгээний ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тусгай тоног төхөөрөмжийн ашиглалтад суралцаж, бие даан үүрэг гүйцэтгэнэ.

- Аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, цаашид аврах ажиллагааны болон эмнэлгийн багаж хэрэгсэл, тусгай тоног төхөөрөмжүүдийг ашиглах мэдлэг, чадварыг бүрэн эзэмшсэн байна.

2. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хүрээ

Төсөл хэрэгжүүлэгч: Онцгой байдлын ерөнхий газар

Төсөл хэрэгжих хугацаа: 2023 он–2026 он /3 жил/

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас олгох 24.7 сая еврогийн зээл нь жилийн 0.282 хувийн хүүтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй. Төслийн хүрээнд хийгдэх ажлыг төсөвт өртгийн задаргааны хамт доорх хүснэгтэд харуулав:

/сая евро/

№	Хийх ажил	Төсөвт өртөг
1	Засвар үйлчилгээ /нисдэг тэрэгний тоног төхөөрөмж/	5.1
2	Программ хангамж	6.6
3	Сургалт	13.0
Нийт		24.7

3. Бодлогын баримт бичигт туссан байдал

“Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл” нь дараах бодлогын баримт бичигт туссан болно. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.20-д “Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд сансрын болон бусад дэвшилтэт арга технологи, техник хэрэгсэл, багаж төхөөрөмж нэвтрүүлж, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ” гэж;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.11-д “Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.” гэж тус тус заасан байна.

4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2023-2024 оны хооронд эдийн засаг харгалзан 6.0 хувь, 7.0 хувиар өсөж, Монгол Улсын 2023 оны төсөв, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 44.3 хувь, 2024 онд 42.7 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСЛИЙН
САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН
САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Бүртгэлийн дугаар 325

МОНГОЛ УЛСЫН
ТАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ХҮҮЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны газрын үсэг

2023 оны 12 сарын 19-ний өдөр

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь (цаашид "Талууд" гэх)

найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихийг эрмэлздэгээ илэрхийлж,

олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцэх, нийгмийн болон байгаль орчны хариуцлагад тууштай байр суурь сахихын чухлыг тэмдэглэн,

тэгш эрх, харилцан ашигтай байх зарчимд суурилан

дараах зүйлийг харилцан тохиролцов:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ДҮН, АГУУЛГА

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь Онцгой байдлын ерөнхий газарт агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөлд зориулан Монгол Улсын Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрөв. Энэхүү төсөл нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлд багтаж буй.

Францын Төрийн сангийн нэн хөнгөлөлттэй зээл хэлбэрээр 24 764 120 € /хорин дөрвөн сая долоон зуун жаран дөрвөн мянга нэг зуун хорин евро/-ны нийт үнийн дүнтэй энэхүү санхүүгийн дэмжлэг нь дээр дурдсан төслийн гүйцэтгэлийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Бүгд Найрамдах Франц Улсаас францын бараа, үйлчилгээ худалдан авах;
- Олгосон санхүүгийн дэмжлэгийн 30-аас хэтрэхгүй хувийг монголын болон гуравдагч орны бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулах, холбогдох гэрээг францын гүйцэтгэгчийн хариуцлагын дор хэрэгжүүлнэ.

Энэхүү зээлтэй холбогдох гэрээ эсхүл гэрээнүүдийн гүйцэтгэлийг францын ханган нийлүүлэгч тал хариуцна.

2 ДУГААР ЗҮЙЛ – ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭЛБЭР

Гэрээ тус бүрийн төслийг эхлүүлэх урьдчилгаа төлбөрийг 1 дүгээр зүйлд дурдсан Төслийн хүрээнд Францын Төрийн сангийн зээлээр санхүүжүүлнэ.

Төсөл эхлүүлэх урьдчилгааны дүн нь тээвэр болон даатгалын зардлыг оролцуулалгүйгээр зээлийн нийт дүнгийн арван таван хувь (15%) байна.



Энэхүү хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх гэрээнүүдийн францын талын ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлнэ.

3 ДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН НӨХЦӨЛ, ХЭЛБЭР

Францын Төрийн сангийн зээлийн хугацаа 20 жил бөгөөд үндсэн зээлийн төлбөрөөс эхний 5 жил чөлөөлөгдөнө. Зээлийн хүү жилийн 0,282 хувь байна. Үндсэн зээлийг хагас жил тутам ижил хэмжээтэй, дараалсан 40 удаагийн төлбөрөөр эргүүлэн төлөх ба эхний төлбөрийг тухайн зээл олгогдсон улирал дууссанаас хойш 66 сарын дараа хийнэ. Хүүг үндсэн зээлийн үлдэгдэл дүнгээс бодно. Тухайлбал Францын Төрийн сангаас санхүүжилт олгосон огноо тус бүрээс эхлэн тооцож, хагас жил тутам эргүүлэн төлнө.

Үндсэн зээл, эсхүл зээлийн хүү төлөх огноо нь Монголд эсхүл Францад ажлын бус өдөр таарвал, төлбөрийг дараагийн ажлын эхний өдөр хүртэл хойшлуулна. Үндсэн зээл эсхүл хүүгийн эргэн төлөлтийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлөлт хийх ёстой байсан өдрөөс хийгдсэн өдөр хүртэл хугацаа хэтэрсний хүү тооцно. Хугацаа хэтэрсний хүүг Еврогийн богино хугацааны индекс-Euro Short Term Rate /ESTR/-н ханшаар жилийн 4 % нэмж тооцох ба энэ нь жилийн 5 % хэтрэхгүй. Хэрэв хугацаа хэтэрсний хүү нь бүтэн жилээр хоцорвол дээр дурдсан ханшаар хүүгийн хүү тооцно.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Францын нийтийн хөрөнгө оруулалтын банк (Bpifrance Assurance Export) /банкийг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага/ Зээлийн гэрээг байгуулна. Тус гэрээнд Францын Төрийн сангийн зээлийн ашиглах болон эргэн төлөх хэлбэрүүдийг тодотгож өгнө.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨЛБӨР, ТООЦООНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэхүү Хэлэлцээртэй холбоотой төлбөр, тооцооны мөнгөн тэмдэгт нь евро байна.

5 ДУГААР ЗҮЙЛ – ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ бүрийг байгуулахдаа дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- (i) Урьдчилсан байдлаар төсөлд хийсэн дүгнэлтээс гарсан зааварчилгаатай нийцэж, агуулга, дурдсан үйлчилгээ, холбогдох үнэ өртгийн хувьд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраар баталгаажсан байх;
- (ii) Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын дүрэм, журамтай төсөл нийцэж буй эсэхийг шалгасан байх;

3

Бүртгэлийн дугаар	325
МОНГОЛ УЛСЫН	
ГАЗАР	
ХУУЛБАР ҮНЭН	
Хуулбар олгосон ажиглалтын гарын үсэг	
2023 оны 12 сарын 0-ний өдөр	

- (iii) Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Францын хөгжлийн агентлаг, Клуб дэ Парис /Club de Paris/-тай байгуулсан өмнөх зээлүүдийн хувьд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- (iv) Монгол Улсын Засгийн газарт эсхүл түүний аль нэг төрийн байгууллагад олгосон, эсхүл Монгол Улсын Засгийн газар баталгаа гаргасан этгээдэд Франц Улсаас баталгаа гаргаж олгосон банкны зээлийн хүрээнд хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл байгаа эсэхийг шалгасан байх;
- (v) Энэхүү Хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд заасан үүрэг амлалтын биелэлтийн нөхцөлийг хангах;

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ тус бүр дээрх нөхцөлүүдийг бүрэн гүйцэд хангаж байна гэж францын эрх бүхий байгууллага үзвэл, түүний зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсад суугаа Францын Элчин сайдын яамны Эдийн засгийн албаны дарга Монгол Улсын Сангийн яамтай захидал солилцсоноор уг гэрээ энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхлэх үндэс бүрдэнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ – АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Талууд энэхүү Хэлэлцээрийн оршилд олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцлийг дэмждэгээ илэрхийлсэн.

Уг хэлэлцээрийн хүрээнд гэрээ байгуулах талууд нь өөрсдийн болон өөр нэг талын ашиг сонирхлын тулд гуравдагч этгээдэд шууд болон шууд бус замаар хууль бус үйл ажиллагаа, авлига авах нөхцөлийг бүрдүүлж болохуйц шударга бус, мөнгөтэй холбоотой эсвэл бусад давуу талыг санал болгох, олгох, амлах, мөн түүнтэй адилтгах зүйлийг тэднээс шаардаж болохгүй.

Талууд уг төслийн хүрээнд авлигын аливаа үйлдэл бий болгохгүй байх үүрэгтэй. Талууд нь сэжиг бүхий нөхцөл байдлын талаар мэдмэгцээ харилцан мэдээлэх, нөхцөл байдлыг арилгахын тулд шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын сэтгэл ханамжид нийцүүлэх үүрэг хүлээнэ.

Дээр дурдсан үүргүүдийг биелүүлээгүй тохиолдолд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь өөрийн зүгээс хамгийн зохимжтой гэж үзэх гэрээ байгуулахаас татгалзах, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохиролцсон санхүүгийн тусламжийн төлбөрийг түдгэлзүүлэх, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгосон санхүүжилтийг нийтэд нь эсхүл хэсгийг нь тохирсон хугацаанаас эрт төлөхийг шаардах эрхтэй.

4

Бүртгэлийн дугаар 325

МОНГОЛ УЛСЫН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ХҮҮЛСЭЭ ҮНЭН

Хуулбар олгосон эжилтний сарын үсэг

2023 оны 12 сарын 19 нийт одоо

7 ДУГААР ЗҮЙЛ – НИЙГМИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Талууд нь Олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн байгаль орчны болон нийгмийн хэм хэмжээ, үүний дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл мөн хүрээлэн буй орчны талаарх олон улсын конвенцуудыг, тухайлбал удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцыг мөн Олон улсыг санхүүгийн корпорацын гүйцэтгэлийн стандартуудыг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих шаардлагатай гэдэгт талууд санал нэгдэв.

8 ДУГААР ЗҮЙЛ – БАЙГАЛИЙН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮЕД ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ ЦАРЦААХ БОЛОН ХОЙШЛУУЛАХ БОЛОМЖ

Цаг уурын давагдашгүй онцгой үзэгдлийн үед, зээлдэгч тал зээлийн эргэн төлөлтийг түр зогсоох хүсэлтийг, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн Яам, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Францын нийтийн хөрөнгө оруулалтын банк (Bpifrance Assurance Export) /банкийг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага/ хооронд байгуулсан Зээлийн гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын Өрийн албанд гаргаж болно.

Энэхүү төслийн хүрээнд хамаарах өр зээлийн үйлчилгээг түр зогсоох хүсэлтийг Францын Өрийн албанд хамгийн ихдээ гурван удаа гаргана.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХУГАЦАА

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан санхүүгийн дэмжлэгийг авахын тулд, францын гүйцэтгэгч болон монголын захиалагчийн хооронд гарын үсэг зурсан гэрээний эрх 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор нээгдсэн байна.

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгож буй Францын Төрийн Сангийн зээлийн хөрөнгийг 2028 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор ашиглаж дууссан байна.

Зөвхөн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд дээрх хугацааг Талууд албан бичиг солилцон харилцан санал нэгдсэний дараа сунгаж болно.

10 ДУГААР ЗҮЙЛ – ТАТВАР, ХУРААМЖ

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан татварын хэлэлцээрт өөрөөр заасан байсан ч, уг Хэлэлцээрийн хүрээнд төлөвлөсөн санхүүжилтийг

Бүртгэлийн дугаар 305

МОНГОЛ УЛСЫН

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2023 оны 12 сарын 19-ний өдөр

Монгол Улсын хөгжилд бүрэн ашиглах үүднээс энэхүү Хэлэлцээрийн хүрэн дэх франц компаниудын бараа үйлчилгээ, техникийн туслалцаа, тэдгээр ханган нийлүүлэлтийн үйлдвэрлэлд багтаж буй бараа, үйлчилгээг импортлох, экспортлох, худалдан авах, ашиглах, захиран зарцуулах зэрэг үйл ажиллагаанд аливаа гаалийн болон бусад татвар, нийгмийн даатгал, шимтгэл хураамж болон Монгол Улсад шаардагддаг бусад ямар ч албан хураамж ногдуулахгүй байхаар тохиролцов.

Хэрэв Монгол Улсад мөрдөгддөг дүрэм, журмын дагуу агуулга, зориулалтаас үл хамааран зайлшгүй татвар, хураамж төлөхөөр болсон тохиолдолд түүнийг францын тал эсвэл францын компаниуд хариуцахгүй.

Мөн энэхүү санхүүгийн Хэлэлцээрийн гүйцэтгэлтэй холбоотой үндсэн зээлийн болон хүүгийн эргэн төлөлт, шимтгэл, хураамж, дагалдах төлбөр нь Монгол Улсад мөрдөгддөг бүхий л албан татвар, хураамж нэмэгдээгүй цэвэр дүнгээр бодогдоно.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар өөрийн зардлаар энэхүү хэлэлцээрт тусгасан төслийн зорилго биелсэн эсэхийг эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдээр дүгнэн гаргаж болно. Хэрэв шаардлагатай бол Монгол Улсын Засгийн газар энэхүү судалгааны үр дүнг шууд хүртэх үүднээс үүнд оролцох боломжтой ба оролцох хэлбэрийг тухайлан тодорхойлно. Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас томилсон дээрх судалгаа, дүгнэлт хийх шинжээчдийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг хүлээнэ.

12 ДУГААР ЗҮЙЛ – ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат замаар, бичгээр харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

13 ДУГААР ЗҮЙЛ – ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Энэхүү хэлэлцээрт Талууд бичгээр санал нэгтэй тохиролцсоныг үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь уг хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ – МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүдэн гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвлөлдөх, хэлэлцэх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Бүртгэлийн дугаар 325

МОНГОЛ УЛСЫН

ХУУЛЬ ОРОН

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2027 оны 10 сарын 0-ний өдөр

Дээр дурдсаныг хүлээн зөвшөөрч хоёр улсын Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж, тамгалав.

Парис хот. 2023 оны 10 дугаар сарын-ний өдөр.

Монгол, Франц хэлээр хоёр эх хувь үйлдэв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:



БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:



Бүртгэлийн дугаар 325

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЦААНЫ ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

2023 оны 12 сарын 19-ний өдөр



PROTOCOLE FINANCIER

ENTRE

LE GOUVERNEMENT DE LA MONGOLIE

ET

LE GOUVERNEMENT DE LA RÉPUBLIQUE FRANÇAISE

CONTRIBUANT AU FINANCEMENT DU PROJET DE FORMATION
COMPLÉMENTAIRE DE L'UNITÉ DE SECOURS AÉRIEN DE L'AGENCE
NATIONALE DE GESTION D'URGENCES

Бүртгэлийн дугаар

325

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ХУУЛЬ АР ҮЧЭЧ

Хуулбар олгосон ажиглалтын таван үсэг

2023 оны 12 сарын 19-ний өдөр

Le Gouvernement de la Mongolie et le Gouvernement de la République française, ci-après individuellement désignés « la Partie » et collectivement « les Parties »,

Désireux de renforcer les liens d'amitié et de coopération qui les unissent et de favoriser le développement économique de la Mongolie,

Rappelant leur attachement à la lutte contre la corruption dans les transactions commerciales internationales et à la responsabilité sociale et environnementale,

Agissant sur une base d'égalité et de bénéfices mutuels,

Sont convenus des dispositions suivantes :

ARTICLE 1 - MONTANT ET OBJET DES CONCOURS FINANCIERS

Le Gouvernement de la République française consent au Gouvernement de la Mongolie des concours financiers destinés au projet de formation complémentaire de l'unité de secours aérien de l'Agence Nationale de Gestion d'Urgences. Ledit projet s'inscrivant dans les priorités du Gouvernement de la Mongolie.

Ces concours, sous la forme d'un prêt concessionnel du Trésor français d'un montant maximal de 24 764 120 € (vingt-quatre millions sept cent soixante-quatre mille cent vingt euros), financent pour l'exécution du projet mentionné ci-dessus :

- l'achat en France de biens et services français ;
- l'achat de biens et services mongols ou étrangers, dans la limite de 30 % (trente pour cent) du montant des concours financiers, l'exécution des contrats étant sous la responsabilité des fournisseurs français.

L'exécution du ou des contrat(s) de marché y relatif (s) étant sous la responsabilité des fournisseurs français.

ARTICLE 2 – MODALITÉS DE FINANCEMENT DU PROJET

Le paiement de l'avance de démarrage relatif à chaque contrat sera financé par le prêt du Trésor français dans le cadre du Projet mentionné à l'article 1^{er}.

Ladite avance de démarrage est de quinze pour cent (15 %) du montant du Marché, les frais de transport et d'assurance n'étant pas pris en compte pour le calcul du montant de l'avance de démarrage.

Le choix des fournisseurs français dont les contrats sont financés dans le cadre du présent Protocole est effectué conformément à la législation de la Mongolie.

ARTICLE 3 – CONDITIONS ET MODALITÉS DE MISE EN PLACE DES CONCOURS FINANCIERS

Le prêt du Trésor français est consenti pour une durée de 20 ans, dont 5 ans de franchise. Le taux d'intérêt est de 0.282 % l'an. Le principal est remboursable en 30 échéances semestrielles égales et successives, la première étant exigible 66 mois après la fin du trimestre civil au cours duquel les tirages ont été effectués. Les intérêts sont



calculés sur le montant du principal restant dû ; ils courent à partir de la date de chaque tirage sur le prêt du Trésor français et sont payés semestriellement.

La date de règlement d'une échéance de principal ou d'intérêt est, lorsqu'elle échoit un jour non ouvré en Mongolie ou en France, repoussée au premier jour ouvré qui suit. Toute échéance de principal ou d'intérêt non réglée à bonne date donne lieu à intérêts de retard à compter du jour de l'exigibilité jusqu'au jour du paiement effectif. Les intérêts de retard sont calculés au taux Euro Short Term Rate (ESTR) majoré de 4 % l'an, ce taux ne pouvant toutefois être supérieur à 5 % l'an. Les intérêts de retard portent eux-mêmes intérêt au taux défini ci-dessus s'ils sont dus pour une année entière.

Une convention de financement est signée entre le Ministère des Finances de la Mongolie, agissant au nom et pour le compte du Gouvernement de la Mongolie et Bpifrance Assurance Export (Domaine des Activités Institutionnelles), agissant au nom et pour le compte du Gouvernement de la République française. Elle précise les modalités d'utilisation et de remboursement du prêt du Trésor français.

ARTICLE 4 - MONNAIE DE COMPTE ET DE PAIEMENT


La monnaie de compte et de paiement au titre du présent Protocole est l'euro.

ARTICLE 5 - IMPUTATION DES CONTRATS

L'imputation de chaque contrat relatif au Projet mentionné à l'article 1^{er} du présent Protocole est conditionnée :

- (i) à la conformité du contrat avec les recommandations formulées par l'évaluation préalable du projet correspondant au dit contrat et à la validation par le Gouvernement de la République française de son contenu, des prestations y figurant et des prix afférents;
- (ii) à la vérification de la conformité du projet avec les dispositions prévues par l'Arrangement de l'Organisation de Coopération et de Développement Économiques (OCDE) relatif aux crédits à l'exportation bénéficiant d'un soutien public;
- (iii) à l'absence de montants dus et non réglés à bonne date par le Gouvernement de la Mongolie au titre des accords de consolidation de dette intervenus en Club de Paris, des prêts gouvernementaux français et des prêts de l'Agence française de développement;
- (iv) à l'examen de l'état des montants dus et non réglés à bonne date au titre des crédits bancaires garantis par l'État français accordés au Gouvernement de la Mongolie ou à son secteur public, ou qui bénéficient de la garantie du Gouvernement de la Mongolie;
- (v) au respect des engagements pris aux articles 6 et 7 du présent Protocole.

Chaque contrat relatif au projet mentionné à l'article 1^{er} est imputé sur le présent Protocole, après que les autorités françaises compétentes ont constaté que ces conditions sont dûment remplies, par un échange de lettres entre le Ministère des Finances de la Mongolie, agissant au nom et pour le compte du Gouvernement de la Mongolie et le Chef du Service économique régional près l'Ambassade de France en Mongolie, agissant avec l'autorisation des autorités françaises compétentes.



ARTICLE 6 – ENGAGEMENTS EN FAVEUR DE LA LUTTE CONTRE LA CORRUPTION

Les Parties rappellent leur attachement à la lutte contre la corruption dans les transactions commerciales internationales.

Les parties aux contrats imputés sur le présent Protocole ne peuvent proposer ou donner à un tiers, demander, accepter ou se faire promettre, directement ou indirectement, pour leur bénéfice ou celui d'une autre partie aucun avantage indu, pécuniaire ou autre, constituant ou pouvant constituer une pratique illégale et de corruption.

Les Parties s'engagent à ce que le Projet mentionné à l'article 1^{er} ne donne pas lieu à des actes de corruption. Elles s'engagent à s'informer mutuellement dès qu'elles ont connaissance d'informations faisant peser des soupçons, et à prendre les mesures nécessaires pour qu'il y soit remédié, dans le délai imparti et à la satisfaction du Gouvernement de la République française.

En cas de non-respect des engagements cités ci-dessus, le Gouvernement de la République française se réserve le droit, en fonction de ce qui lui paraît le plus pertinent, de refuser l'imputation d'un contrat et/ou de suspendre les décaissements des concours financiers consentis au Gouvernement de la Mongolie et/ou d'exiger le remboursement anticipé de tout ou partie des concours financiers consentis au Gouvernement de la Mongolie.

ARTICLE 7 - ENGAGEMENTS EN FAVEUR DE LA RESPONSABILITE SOCIALE ET ENVIRONNEMENTALE

Afin de promouvoir un développement durable, les Parties conviennent qu'il est nécessaire d'encourager le respect des normes environnementales et sociales reconnues par la communauté internationale, parmi lesquelles figurent les conventions internationales de l'Organisation Internationale du Travail (OIT) et de l'Organisation des Nations Unies (ONU) en matière de changement climatique, de biodiversité et d'environnement, notamment la Convention de Stockholm sur les polluants organiques persistants, ainsi que les normes de performance de la Société Financière Internationale.

ARTICLE 8 – POSSIBILITÉ DE GEL ET REPORT DU REMBOURSEMENT EN CAS DE CATASTROPHE CLIMATIQUE

En cas d'évènement climatique extrême, l'emprunteur peut solliciter une suspension du service de la dette auprès du Gouvernement de la République française selon des conditions définies dans la convention de financement signée entre le Ministère des Finances de la Mongolie, agissant au nom et pour le compte du Gouvernement de la Mongolie et Bpifrance Assurance Export (Domaine des Activités institutionnelles), agissant au nom et pour le compte du Gouvernement de la République française.

Il n'est pas possible de solliciter plus de trois suspensions du service de la dette auprès de l'État français au titre du présent Projet.

Бүртгэлийн дугаар 325
МОНГОЛ УЛСЫН
САГААД ХАРИУЦААН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
2023 оны 12 сарын 19-ний өдөр

ARTICLE 9 - DATES LIMITES DES CONCOURS FINANCIERS

Pour bénéficier des concours financiers définis à l'article 1^{er} ci-dessus, les contrats signés entre acheteurs mongols et fournisseurs français doivent être imputés au plus tard le 31/03/2024.

Les tirages sur le prêt du Trésor français accordé par le présent Protocole doivent être réalisés au plus tard le 31/03/2028.

Ces dates ne peuvent être prorogées qu'en cas de circonstances exceptionnelles après accord mutuel par un échange de lettres entre les Parties.

ARTICLE 10 - IMPÔTS ET TAXES

Nonobstant les dispositions de la convention fiscale signée entre le Gouvernement de la Mongolie et le Gouvernement de la République française le 18 avril 1996 et aux fins de réserver les financements prévus par le présent protocole au développement de la Mongolie, il est entendu que, pour les contrats imputés, la fourniture de biens et services, y compris l'assistance technique, par des entreprises françaises dans le cadre du présent protocole, de même que l'importation, l'exportation, l'achat, l'utilisation ou la disposition de biens et services concourant à la production de telles fournitures, ne subiront aucuns droits de douane, taxes, cotisations sociales ni autres prélèvements obligatoires en Mongolie.

Si de tels prélèvements, quel que soit leur objet ou leur nature, doivent être effectués selon les règles mongoles sur les opérations précitées, le paiement de ceux-ci n'est pas à la charge de la partie française ou des entreprises françaises.

De plus, le remboursement du principal et le paiement des intérêts, commissions, frais et accessoires liés à l'exécution du présent Protocole financier sont effectués nets de tout impôt et de toute autre charge public applicable en Mongolie.

ARTICLE 11 - ÉVALUATION RÉTROSPECTIVE DU PROJET

Le Gouvernement de la République française peut procéder à ses propres frais à l'évaluation rétrospective, sur les plans économique, financier et comptable, du Projet mis en œuvre en application du présent Protocole de manière notamment à s'assurer que le Projet a atteint ses objectifs. Le Gouvernement de la Mongolie est associé, s'il le souhaite, à la conduite de cette évaluation, selon des modalités qui sont à définir, afin de bénéficier directement des résultats de l'étude. Le Gouvernement de la Mongolie s'engage à accueillir la mission d'évaluation envoyée par le Gouvernement de la République française et à lui faciliter l'accès aux informations concernant le Projet.

ARTICLE 12 - ENTRÉE EN VIGUEUR

Le présent Protocole entre en vigueur à la date de la réception de la dernière notification écrite transmise par voie diplomatique confirmant l'accomplissement par chacune des Parties des procédures internes nécessaires à son entrée en vigueur.



ARTICLE 13 – AVENANT AU PROTOCOLE

Le présent Protocole est amendé par un accord mutuel écrit entre les Parties. De tels amendements font partie intégrante du présent Protocole.

ARTICLE 14 – RÈGLEMENT DES DIFFÉRENDS

Tout différend relatif à l'interprétation ou à la mise en œuvre du présent Protocole est réglé à l'amiable par voie de consultation ou de négociation entre les Parties.

EN FOI DE QUOI, les représentants des deux Gouvernements, dûment autorisés à cet effet par leurs Gouvernements respectifs, ont signé le présent protocole et y ont apposé leur sceau.

Fait à _____ le _____

En 02 (deux) exemplaires originaux, en langues mongole et française.

Pour le Gouvernement
de la Mongolie

Pour le Gouvernement
de la République française



Бүртгэлийн дугаар _____ 25
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН

2023 оны 12 сарын 12-ний өдөр

НЭГ. “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛЫН ТАЙЛАН

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл (цаашид хуулийн төсөл гэх)-ийн үзэл баримтлалыг гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, найдвартай хүргэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, хуулийн төсөл батлагдаж Санхүүгийн хэлэлцээрт заасан төсөл хэрэгжсэнээр Онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын автомашин, техник тоног, төхөөрөмжийн хангалтын хувь, хүний нөөцийн чадавхыг сайжруулах үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааг үндэслэн боловсруулсан.

(Хүснэгт 1)

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах асуудал	Тусгасан Эсэх
Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага	Тийм
Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Тийм
Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал	Тийм
Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал	Тийм

Хуулийн төслийн үг хэллэг нь оновчтой, нийтээр нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэхгүй, хэл зүй, найруулгад тавигдах шаардлагыг хангасан байхаар боловсруулсан бөгөөд дараах шаардлагад нийцүүлсэн болно.

(Хүснэгт 2)

Шаардлага	Нийцсэн байдал
Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Энэ хууль нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгах	Туссан.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Тусгагдаагүй.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Тусгагдаагүй
Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Нэг зүйлтэй хуулийн төсөл тул хоорондоо зөрчилдөх зүйл, хэсэг, заалт байхгүй.

Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинэжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Тусгагдаагүй
--	--------------

---oOo---

ХОЁР. “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. Ерөнхий зүйл

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2019.10.06-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хэлэлцээр”-ийн (УИХ-ын 2019.12.20-ны өдрийн чуулганаар соёрхон баталсан) хүрээнд “Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад Агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл”-ийн I үе шатыг хэрэгжүүлсэн.

Агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төслийн I үе шат дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:

(Хүснэгт 1)

Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн:	• Airbus EC-145 маркийн 3 нисдэг тэрэг (эмнэлгийн болон аврах ажиллагааны хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон) • Guimbal Cabri маркийн сургалтын 1 нисдэг тэрэг • Utilis SAS засвар үйлчилгээний төв бүхий ангар, оффис • THALES сургалтын дадлагажуулах/симулятор • Онгоцны түлш цэнэглэх станц, газрын ажиллагааны тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд ашиглагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгсэл • Төсөл хэрэгжих хугацаанд нисдэг тэрэг, симуляторын хуваарьт засвар, үйлчилгээ, шаардагдах сэлбэг хэрэгсэл.
Сургалт:	- Анхан шатнаас 8, өмнө нь нисэж байсан туршлагатай 4 нисэгчийн хөрвүүлэх сургалтад буюу нийт 12 нисэгч, - 12 инженер, авианик, техникийн ажилтан, - Агаарын аврах ажиллагааны 3 мэргэжилтэн, 4 аврагч, - 4 парамедик буюу аврах ажиллагааны үед эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх ажилтныг тус тус бэлтгэж байна.
Үүрэг гүйцэтгэсэн байдал:	- Агаараас эрэн хайх, аврах анги нь 2023-р 9-р сарын байдлаар 85 удаагийн дуудлагаар тусгай үүргийн нислэг үйлдэж ослын улмаас бэртэж гэмтэн, газраар тээвэрлэх боломжгүй амь насаа алдах өндөр эрсдэлд орсон 122 хүний амь нас, аюулгүй байдлыг ханган анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн дараагийн шатны эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй шуурхай хүргэж өгсөн. - Ой, хээрийн түймрийг унтраахад гал сөнөөгч, аврагчдыг авто тээвэр болон өрдийн хөсгөөр очих боломжгүй газруудад шуурхай тараан байршуулж түймрийг цаг алдалгүй, тархаалгүй унтраахад чухал үүргийг гүйцэтгэж байна. - “Агаараас нэрвэгдэгчийг урсгал болон тогтмол усны мандлаас эрэн хайх, аврах ажиллагаа”, “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа”, “Өргөгч төхөөрөмжтэй ажиллах инженер техникийн ажиллагаа” сэдэвт дадлага, сургалтуудыг Монгол Улсад анх удаа өөрийн улсын цаг уур, газар орны нөхцөлд тохируулан зохион байгуулсан.

Хугацаа:	Төслийг хэрэгжүүлэгч БНФУ-ын Хели Юнион (Heli Union) компанитай 2020 оны 4 сараас 2023 оны 4 сарыг дуустал хугацаанд төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан. Нэмэлт гэрээний өөрчлөлтөөр зардал, төсөв нэмэгдүүлэхгүйгээр 6 сарын хугацаагаар сунгасан.
----------	---

2. Урьдчилан тандан судлах ажлын үе шат

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын (цаашид Аргачлал гэх) 2-т заасан үе шат бүрээр Хуулийн төслийг тандан судлах ажлыг зохион байгууллаа.

3. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

"Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад Агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл"-ийн I үе шаттай амжилттай хэрэгжсэн тул төслийн II үе шат буюу "Онцгой байдлын ерөнхий газрын Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Санхүүгийн хэлэлцээрийг батлуулах зорилгоор Хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөл нь Аргачлалын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

"Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад Агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл"-ийн I үе шатанд бэлтгэгдэж байгаа 1 нисэгч төсөл хэрэгжих хугацаанд (2020-2023 он) бие даан нисэх лицензтэй, 100 гаруй цагийн дадлагын нислэг үйлдсэн туршлагатай болно. Энэ нь олон улсын жишгээр эрэн хайх, аврах ажиллагааны онцгой хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэх нисэгчид тавигдах шаардлагыг хангахааргүй байна. Тухайлбал Франц Улсын Иргэний аюулгүй байдлыг хамгаалах буюу онцгой байдлын байгууллагын нисэгч доод тал нь 2000 цагаас дээш нислэгийн туршлагатай байх шаардлагыг тавьдаг байна. Төслийн хүрээнд бэлтгэгдэж байгаа 1 нисэгчийг Airbus EC-145 агаарын хөлгөөр доод тал нь 500 цагаас дээш нислэг үйлдсэн туршлагатай болгохын тулд 8 нисэгч нийт 4000 цагийн нислэг үйлдэх шаардлага үүсэж байна. Нэг жилийн хугацаанд 3 нисдэг тэрэгний нислэг үйлдэх боломжит цаг нь дунджаар 2160 цаг бөгөөд онцгой, тусгай үүргийн болон сургалтын нислэгийг харгалзан тооцоход 4000 цагийн нислэгийг 3-5 жилийн хугацаанд үйлдэх боломжтой байна.

Инженер техникийн бүрэлдэхүүн болох 12 алба хаагч нь Airbus EC-145 агаарын хөлгийн SAFRAN хөдөлгүүрийн I шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан бөгөөд цаашид II шатны сургалтад хамрагдах шаардлагатай байна. Энэ сургалтад хамрагдсанаар нисдэг тэрэгний хөдөлгүүрийг задалж угсрах, техникийн үйлчилгээ, засварыг бие даан гүйцэтгэх чадвартай болно.

Иймд Онцгой байдлын байгууллагын нисэгч, инженер, техникийн ажилтнуудыг үргэлжлүүлэн сургаж бэлтгэхэд Франц Улсын нисэгч, инженер техникийн ажилтан, багш нарыг Монгол Улсад ажиллуулах, Онцгой байдлын нисэгч, инженер техникийн ажилтнуудыг Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний аюулгүй байдлын газар, түүний харьяа агаарын ажиллагааны бааз болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургалтын төвд сургаж дадлагажуулах, нисдэг тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээг хийхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэн төслийг өргөжүүлэн II үе шатыг эхлүүлэх шаардлага үүсэж байна.

Монгол Улсад жилд дунджаар 500 орчим зам тээврийн ослын улмаас амь насаа алддаг бөгөөд нэрвэгдэгчдийн 80.0 гаруй хувь нь анхан шатны тусламж авч чадалгүй нас бардаг байна.¹



4. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна. "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Санхүүгийн хэлэлцээрийг батлуулах хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэсэн зорилтын тодорхойлж байна.

5. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зөрөг, сөрөг талыг харьцуулсан байдал

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн "8 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ", "8.1. Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална.", "8.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн

¹ <https://montsame.mn/mn/read/306266>, https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_039V3

талаархи олон улсын гэрээ," гэж заасан тул Аргачлалын 5.4.3-т заасны дагуу хуулийн төсөл шууд боловсруулах хувилбарыг сонголоо.

6. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	-	-	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	-	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.	
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	-	-	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээг зөрчиж байгаа зохицуулалт байхгүй.	
	1.2. Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	-	-	Тодорхой зорилтот бүлэгт чиглээгүй нийт иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чадавхыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ болно.	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	-	-	Бүлгүүдийг тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.	
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	-	Ард иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах нөхцөл сайжрана.	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	-	Уг зөвлөмжтэй зөрчилдөх агуулга байхгүй.	зөрчилдөх
		1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	-	Үгүй	Хариуцлагатай зохицуулалт шаардлагагүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	-	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.	

	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	-	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	-	Үгүй	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	-	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	-	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн зохицуулалт агуулаагүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	-	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	-	Онцгой байдлын байгууллагын алба хаагч үүрэг хүлээнэ.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	-	Үгүй	Жендерийн үзэл баримтлалтыг зохицуулалт агуулгагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	-	Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	-	-	Аливаа өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	-	БНФУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд Монгол Улсад хөрөнгө оруулах, үйл ажиллагаа явуулахад жишиг төсөл болох эерэг талтай.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	-	Үгүй		
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	-	Үгүй		
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	-	Үгүй		
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	-	Үгүй		
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй		
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	-	БНФУ-д үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нийлүүлэгдэнэ. Олгосон санхүүжилтийн 30 хувиас ихгүй хувьд бусад улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн худалдаж авч болно.	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	-	Үгүй		
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	-	Үгүй		
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	-	Үгүй		
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	-	Үгүй		
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	-	Үгүй		
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	-	Үгүй		
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	-	Үгүй		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	-	Үгүй		

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	-	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	-	Монгол Улсад 12 нисдэг тэрэгний нисэгч, 12 инженер техникийн ажилтан бэлтгэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Зарим хангалтын хувцас хэрэглэлийг жижиг, дунд үйлдвэрлэгчээс худалдаж авна.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	24.7 сая.еврогийн зээлийн санхүүжилт шаардагдана.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	-	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	-	Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	-	Монгол Улс, БНФУ хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд жишиг төсөл болно.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	-	Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу хэрэгжинэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал,	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	-	Монгол Улсад 12 нисдэг тэрэгний нисэгч, 12 инженер техникийн ажилтан бэлтгэнэ.

хөдөлмөрийн зах зээл	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	-	Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	-	Онцгой байдлын байгууллагад евро стандартыг нэвтрүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	-	Евро стандартын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтууд хийгдэнэ.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	-	Алба хаагчдын үүрэг хариуцлага нэмэгдэнэ.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	-	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	-	-	Евро стандартын шаардлагад нийцүүлэн зарим өөрчлөлтийг хийнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	-	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	-	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	-	Үгүй	Төслийн хүрээнд гадаадын нисэгч, зааварлагчид ирж ажиллах боловч ямар нэг сөрөг нөлөөлөл байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	-	Онцгой байдлын байгууллагын үүрэг гүйцэтгэх чадавх дээшилнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	-	Гэмтэл ослын улмаас тусламж авч чадахгүй нас барах иргэдийн тоо буурна.

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	-	Ард иргэдийн амар тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд эерэг нөлөөтэй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	-	Онцгой байдлын байгууллагын 24 алба хаагчид нисдэг тэрэгний нисэгч, инженер техникийн ажилтнаар бэлтгэгдэнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Иргэдийн аюулгүй байдлыг хангах, амь насыг аврахад эерэг нөлөө үзүүлнэ.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Иргэдийн аюулгүй байдлыг хангах, амь насыг аврахад эерэг нөлөө үзүүлнэ.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Цагдаагийн байгууллагатай хамтран нисдэг тэргийг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах боломжтой.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	-	Үгүй	

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 5)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	-	Үгүй	Төслийн хүрээнд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэг стандартад заагдсан хэмжээний дагуу түлш зарцуулна.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	-	Төслийн хүрээнд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэг евро стандартын дагуу агаарт ялгаруулах хорт бодис хамгийн бага түвшинд байна.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	-	Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	-	Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	-	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	-	Үгүй	

	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	-	Үгүй	
--	---	---	------	--

7. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын Гуравдугаар бүлгийн 4.1, 4.2, 4.5, Аргачлалын 5.4.3-т заасны дагуу Хуулийн төсөл шууд боловсруулах хувилбарыг сонгосон тул харьцуулалт хийх шаардлагагүй.

8. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх

Хуулийн төсөл нь Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын Гуравдугаар бүлгийн 4.5-д заасны дагуу нэг зүйлтэй тул олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийх шаардлагагүй.

Монгол Улсын Засгийн газар БНФУ-ын Засгийн газар хооронд байгуулсан "Санхүүгийн хэлэлцээр"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй "Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад Агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл"-өөр ашиглаж байгаа Airbus EC-145 загварын нисдэг тэргийг дэлхийн 30 гаруй орны онцгой байдал, эргийн хамгаалалт, цагдаа, хил хамгаалах, зэвсэгт хүчин, эмнэлгийн байгууллагууд ашиглаж байна. Уг загвар нь эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглахад хамгийн тохиромжтой бөгөөд ашиглалтын зардал хэт өндөр бус, аюул осолгүй, шуурхай, найдвартай ажиллагаатай юм. Тухайлбал: 2000 онд ХБНГУ-ын German Luftfahrt-Bundesamt болон Япон Улсын Japanese Civil Aviation Bureau, 2002 онд АНУ-ын Federal Aviation Administration зэрэг байгууллагуудаас аюулгүй ажиллагааны гэрчилгээ авсан байна.

Европын улс орнууд иргэний аюулгүй байдлыг хангах, эрэн хайх аврах зорилгоор нисдэг тэргийг 1950 оны дунд үеэс эхлэн ашиглаж эхэлсэн. Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ)-ын Иргэний аюулгүй байдлын байгууллагын нисэх салбар 23 нисэх баазад 35 нэгж EC-145 загварын нисдэг тэрэгтэй, 230 нисэгчтэйгээр үүрэг гүйцэтгэдэг бөгөөд жилд дунджаар 13.0 мянга гаруй цагийн эрэн хайх, аврах нислэг үйлддэг байна.² ОХУ-ын Онцгой байдлын яам EC-145, МВВ, Ансат, Ка, Ми загварын 60 гаруй нисдэг тэргийг үйл ажиллагаандаа ашиглаж, агаараас эрэн хайх, аврах ажиллагааг явуулж байна.

9. Зөвлөмж

Онцгой байдлын байгууллагын Агаараас эрэн хайх, аврах ангийн үүрэг гүйцэтгэсэн байдлыг харгалзан тооцож үзвэл төслийн II үе шат хэрэгжих хугацаанд (2023-2026 он) нийт 200 гаруй удаагийн дуудлагаар 250-300 иргэний амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор нислэг үйлдэх төлөвтэй байна. Манай улсын ерөнхий зориулалтын нисэхийн салбарт агаараас эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх зориулалтаар тоноглогдсон нисдэг тэрэг одоогийн байдлаар Онцгой байдлын байгууллагаас бусад салбарт байхгүй байна. Иймд Онцгой байдлын

² <https://mobile.interieur.gouv.fr/Le-ministere/Securite-civile>, <https://mchs.gov.ru/>

байгууллагын нисэгчдийг өндөр эрсдэлтэй, цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд нислэг үйлдэх чадавхтай, инженер техникийн ажилтнуудыг агаарын хөлгийн иж бүрэн засвар үйлчилгээг бие даан хийх чадвартай болгох зайлшгүй шаардлагатай байна.

—oOo—

ГУРАВ. "ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

1. Ерөнхий зүйл

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-д (цаашид "Аргачлал" гэх) заасны дагуу дараах үе шаттайгаар хийсэн болно. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

2. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

(Хүснэгт 1)

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх (бүрэн илэрхийлж чадсан эсэх), хуулийн төсөлд туссан зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан.
"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцож үзсэн.
Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтэд	Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарал бүхий этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.
"Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийн батлагдсанаар хэрэгжих төслийн улсын төсөвт нэмэлт зардал үүсгэх эсэх, төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:	Хуулийн төслийг Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.
--	--

3. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон хууль зүйн болон практик үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй учир үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо сонгосон 5 шалгуур үзүүлэлт тус бүрээр үр нөлөөг тогтоох судалгааг хийсэн.

4. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг доорх байдлаар үзүүлэв.

(Хүснэгт 2)

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл. "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.	<u>Зорилгод дүн шинжилгээ хийх:</u> Хуулийн төсөл батлагдсанаар "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл" хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
3	Практикт хэрэгжих боломж		<u>Практикт түрших:</u> Хуулийн төсөл, "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг боловсруулахдаа Агаараас эрэн хайх, аврах ангийн байнгын ажиллагаанд тохиолддог, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд дээр үндэслэж холбогдох байгууллага, хуулийн этгээдүүдээс санал, хүсэлт авах замаар энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж, хуулийн төслийн практик үр нөлөөг тооцсон болно.
4	Ойлгомжтой байдал		<u>Ойлгомжтой байдлыг судлах:</u> Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах

			үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгасан. (Нэг.....хуулийн төсөл боловсруулах аргачлалын тайлангийн Хүснэгт 1-ийг үзэх)
5	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	<u>Зардлын тооцоо хийх:</u>
6	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	<u>Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:</u> Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайлангийн Хүснэгт 3-ийг үзэх

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог үзүүлэв.

(Хүснэгт 3)

Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төсөл нэг зүйлтэй бусад хуулийн заалттай давхардаагүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуульд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн чиг үүргийг давхардуулан хуульчлаагүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Ийм чиг үүргийн харилцааг зохицуулаагүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Санхүүгийн хэлэлцээрийн төсөлд холбогдох Олон улсын гэрээ, Монгол Улсад

	хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу аливаа татвар хураамжаас чөлөөлөгдөхөөр тусгасан.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жөндөрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй. Санхүүгийн хэлэлцээрийн төсөлд талууд авлигаас ангид байх талаар тодорхой үүрэг хүлээсэн.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хариуцлагын хэм хэмжээтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.

5. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Баримтжуулалт: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Хуулийн төслийн хэрэгцээг шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан;
2. Хуулийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төслийн хувилбар;
3. Холбогдох төрийн бус байгууллага, олон нийтийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийн материал;

Оролцогчид Хуулийн төсөл, үзэл баримтлал нь холбогдох хууль тогтоомж, аргачлалын дагуу боловсруулагдсан, нэг зүйлтэй, нэг удаагийн чанартай хуулийн төсөл тул дэмжсэн саналыг өгч байсан бөгөөд хэрэглэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх байдалд ямар нэг өөрчлөлт оруулах санал гаргаагүй болно.

"Онцгой байдлын ерөнхий газрын Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх дараах чиглэлд анхаарч ажиллах саналыг дэвшүүлсэн болно.

- Төслийн хүрээнд бэлтгэгдэж байгаа нисдэг тэрэгний нисэгч, инженер техникийн ажилтнуудыг урт хугацаанд Онцгой байдлын байгууллагад үр дүнтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Цаашид илүү өндөр хүчин чадалтай нисдэг тэрэг ашигладаг болох, орон нутагт шуурхай үүрэг гүйцэтгэдэг чадавхтай байлгах (дуудлага авснаас хойш 2-3 цагийн дотор хүрэлцэн очдог чадавхтай байх); г.м

5.3.Зөвлөмж: "Онцгой байдлын ерөнхий газрын Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц

Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын нисэгчид цаг агаарын ердийн болон хүндрүүлсэн нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломж, нөхцөл бүрдэнэ.
- Өдөр, шөнийн нислэгийн эрхтэй, нисэх багийн дарга 7, хамтран нисгэгч 5 тус тус бэлтгэгдэнэ.
- Инженер техникийн бүрэлдэхүүний техник үйлчилгээ хийх чадвар дээшилж, их бие, хөдөлгүүрийн инженер, техникийн ажилтнууд хоёр дугаар шатны сургалтад хамрагдан ур чадвар нэмэгдэнэ
- Инженер төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн бэлтгэгдэж нисдэг тэрэгний ашиглалтын төлөвлөлтийг боловсруулах, сэлбэг хэрэгслийг захиалах, техник үйлчилгээний ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тусгай тоног төхөөрөмжийн ашиглалтад суралцаж, бие даан үүрэг гүйцэтгэнэ.
- Аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, цаашид аврах ажиллагааны болон эмнэлгийн багаж хэрэгсэл, тусгай тоног төхөөрөмжүүдийг ашиглах мэдлэг, чадварыг бүрэн эзэмшсэн байна.

---oOo---

ДӨРӨВ. “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр батлагдсанаар иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал байхгүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,225,000.0 сая төгрөг хүртэл” гэж тусгасан бөгөөд “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийн зээлийн хөрөнгийн ашиглалт энэ хэмжээнд туссан тул Засгийн газрын нэмэгдүүлэх өрийн хэмжээнд нийцэж байгаа болно.

Түүнчлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2024 онд 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийн 24.7 сая евротой тэнцэх зээлийн хөрөнгийг авч ашигласнаар өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2024 онд 42.7 хувьтай тэнцэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зээлийн хөрөнгө нь жилийн 0.282 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай бөгөөд зээлийн хүүгийн төлбөрт жилд 69,654 евро төлөхөөр байна. Энэ нь 2024 оны төсвийн хүүгийн төлбөрийн зардалд тусгасан дүнтэй харьцуулахад 0.022 хувьтай тэнцэж байгаа тул тус төсөлд төлөх хүүгийн зардал нь улсын төсөвт дарамт учруулахааргүй байна.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүнгийн тухай

2023 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэрээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл, олон нийтийн дунд дараах хэлбэрээр хэлэлцүүлж санал авлаа. Үүнд:

- Сангийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулан (<https://mof.gov.mn/article/entry/newsfpd20231004001>, <https://nema.gov.mn/n/147362>) саналыг цахим шуудангаар авсан.
(цахимаар ирүүлсэн саналын товчоог Хавсралт 1-д үзүүлэв.)
- Холбогдох төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг оролцуулсан хэлэлцүүлэгийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газар дээр зохион байгуулсан.
(оролцогчдоос дэвшүүлсэн саналын товчоог Хавсралт 2-т үзүүлэв.)

Оролцогчид “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал нь холбогдох хууль тогтоомж, аргачлалын дагуу боловсруулагдсан, нэг зүйлтэй, нэг удаагийн чанартай хуулийн төсөл тул дэмжсэн саналыг өгч байсан бөгөөд хэрэглэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх байдалд ямар нэг өөрчлөлт оруулах санал гаргаагүй болно.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудалд дараах саналыг өгсөн байна.

1. Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдыг сургаж дадлагажуулах, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажиллах;

2. Салбар дундын хамтын ажиллагааг хангаж ажилласнаар төсөл хөтөлбөрөөс гарах үр дүн, өгөөж өндөр байх болно. Тухайлбал: Байгалийн гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоо, тооцоолол, аргачлалыг хөгжүүлэх;

3. Гамшигтай тэмцэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр холбогдох яам, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

4. Агаараас эрэн хайх, аврах нэгжийн чадавхыг бэхжүүлж, баруун, зүүн, хойд, урд бүсүүдэд салбар нэмж байгуулах;

5. Боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах чиглэлээр хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, нисэх нэгжийн нисгэгч, инженер техникийн ажилтнуудын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

6. Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны зардлыг эрүүл мэндийн даатгалтай уялдуулах замаар иргэдээс гарах зардлыг бууруулах;

—oOo—

Олон нийтээс цахимаар ирүүлсэн саналын товчоо

№	Иргэний нэр, цахим хаяг	Ирүүлсэн санал
1	Б.Отгонзаяа, ozyuotogonzaya@gmail.com	Ард түмнийхээ аюулгүй амар тайван амьдарлын төлөө томоохон төслүүдийг хэрэгжүүлсэн Онцгой байдлынхандаа баярлалаа. Одоо хэрэгжүүлэх гэж байгаа Нисдэг тэрэг, галын машин нийлүүлэх болон бусад төслүүдийг иргэн хүний хувьд 100 хувь дэмжиж байна.
2	Энх-Амгалан, obaamdaa101@gmail.com	Онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлж байгаа энэхүү төслийг дэмжиж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье
3	Отгонбаяр, otgonbayar.fire2022@gmail.com	Франц Улын төсөл хөтөлбөрөөр Онцгой байдлын байгууллагын гал унтраах автомашин мөн нисдэг тэрэгтэй болж байгаа ард иргэдийн аюулгүй байдал аврах, хор уршгийг арилгахад томоохон ач тустай нийгэмд хэрэгтэй төсөл хөтөлбөр болсон байна. цаашидын улам их өргөжих болтугай ажилд нь амжилт хүсье.
4	П. Чинзориг, chinzorlg.0208@yahoo.com	Улаанбаатар хотын хүн амын нягтрал ихсэж, төрөл бүрийн загвар хийцийн барилга байгууламжууд нэмэгдэж, томоохон хэмжээний уул уурхайн төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа энэ цаг үед Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх цагаа олсон зөв зүйтэй явдал билээ. Энэхүү төсөл хөтөлбөртэй танилцахад манай улсад нэн шаардлагатай, үр дүнтэй төсөл хөтөлбөр бөгөөд Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын техник тоног төхөөрөмжийг дэлхийн стандартад хүргэх нь туйлын чухал юм.
5	С.Алтангэрэл, aagii105.nema@gmail.com	Энэхүү төсөл манай улсад ач холбогдолтой үр өгөөжөө өгсөн сайхан төсөл болсон мөн цаашид үргэлжлүүлэн хэрэгжих гэж байгаад талархаж байна.
6	Ч.Артаг, artaq8484@gmail.com	Франц улсын төслийг иргэний хувьд их дэмжиж байна
7	Д.Багжинням, baljinnyam.0331@gmail.com	Сайн байна уу Танай хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй танилцлаа.Зарчмын хувьд дэмжиж байна.Та бүхний ажил хөдөлмөрт амжилт хүсье.
8	Жагаа, jagaа.nd@gmail.com	Иргэд бидний төлөө цаг наргүй зүтгэдэг танай байгууллагын алба хаагчдад маш их баярлаж явдаг шүү. Эдгээр төслүүд бүгд маш их хэрэгтэй зүйлс болжээ гэж харж дэмжиж байна. Та бүхний ажил амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсье.
9	Уянга, uynqashde@gmail.com	Сайн байна уу. Танай байгууллагаас боловсруулж хэрэгжүүлж байгаа энэхүү төслийг иргэн хүнийхээ хувьд дэмжиж байгаа шүү. Цаашдын ажилд нь амжилт хүсье
10	Д.Алтансүх, suheedovdon@gmail.com	Сүүлийн үед хүн ам (төрөлхтөн)-ын амьдралын хэрэгцээ шаардлага, ахуйн хэрэглээ, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн улмаас гал түймэр гамшиг оёлын тоон үзүүлэлт, төрөл зүйл нь ч нэмэгдэж байна. Үүнтэй уялдуулан Тусгайлан тоноглогосон зориулалтын автомашин техник тоног төхөрөмжийн хангалт хийгдэж орчин цагийн шийдэл цаг үед нийцүүлж байгаа нь

		дэвшилттэй сайшаалтай байна. Автомашин багаж зэвсэглэмжийн хангалт сайжруулсантайгаа уялдуулан хүний нөөцийн бодлогоо сайжруулах, алба хаагчдынхаа ар гэр нийгмийн баталгааг хангах, бүтэц орон тоон тогтвор суурьшилтай ажиллах тал дээр анхаарах нэн шаардлагатай байна. Сүүлийн 5 жилд хүний нөөцийн бодлого уялдаа холбоо маш их алдагдаж алба хаагчид байнгын илүү цагаар ачаалал үүрэн ажиллаж 24 цагаар тулаа хийж байгаа дээр анхаарах
11	Г.Жанчивдорж, gjanчивдорж914@gmail.com	Онцгой байдлын байгууллага нь сүүлийн жилүүдэд техник хэрэгслийн чадамж сайжирч, хөдөө орон нутагт цар хүрээгээ тэлэн олон олон ажлын байр бий болгож, ард иргэдийн амь нас эрүүл мэндэд хөрөнгийг аюул ослоос авран хамгаалж байгаа мөн туулах чадвар сайтай машин техникээр хангагдаж залуучуудад ажиллах урам зориг өгч байна. Аврал эрсэн хүн бүхэнд тэгш үйлчилж байгаа нь сайшаалтай.
12	М.Алтангэрэл, amunkhuu6603@gmail.com	Монгол орны хувьд эрс тэс уур амьсгалтай газар орны хувьд хөгжингүй орнуудтай харцуулахад зам гүүр дэд бүтцийн асуудал сайн биш Иймд онцгой байдлын байгууллага нь орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, ямар ч зам саад бартаанд ажирхааргүй машин техниктэй байх нь зүй ёсны хэрэг юм. Манай улсын онцгой байдлын байгууллага сүүлийн жилүүдэд машин техник, багаж хэрэгсэл, боловсон хүчний хувьд маш хурдтай хөгжиж байгаа байгууллагуудын нэг. Цаашид ч гадны өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа хоолбоотой ажиллах хүчин чадал сайтай машин техникүүдийг өөрийн улс оронд оруулж ирэх тал дээр миний бие үргэлж эерэг байр суурьтай байх болно.
13	Д.Энхтүвшин, enkhutuushin0914@gmail.com	Үйлдвэрлэл барилга байгууламж ихсэж Гал түймэр, гамшиг ослын дуудлага их гарч байгаагаар холбогдуулан хуваарилагдсан Гал унтраах зориулалтын автомашин нь цаг алдалгүй Орон нутгийн барилга байгууламж, ард иргэдийн өмч хөрөнгийн аврах хамгаалан ажиллаж байна. Цаашид үйлдвэрлэл онц чухал объект ихтэй орон нутгуудад гал унтраах зориулалтын автомашины тоог нэмэгдүүлэх, өндөр даралтын хөөсөөр ажилладаг автомашин шаардлагатай байна.
14	Б.Батмөнх, batgerel.9007@gmail.com	Өндөр барилга гэлтгүй уул уурхайн хүнд машин механизмд гарсан гал түймэр унтраахад автомеханик шат хэрэг болох тохиолдол гарч байсан иймд том оврын машин техникт гарсан гал түймэрт ашиглагдах шатны машин бас нийлүүлбэл зохих саналтай байна. Мөн ой хээрийн түймрийг унтраах зориулалтын нисдэг тэрэг нийлүүлж ой хээрийн түймэр зонхилдог аймгуудад туршиж үзэх хэрэгтэй юмуу гэсэн саналууд байна
15	Б.Ууганбаяр, uuganbayard321@gmail.com	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа энэхүү төсөл нь цаг үеэ олоон манай Монгол Улсад нэн шаардлагатай арга хэмжээ болсон төдийгүй цаашид энэ төслийг үргэлжлүүлж Монгол Улсын гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах нь зүй ёсны хэрэг гэж ойлгож байна. Төслийн танилцуулгатай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1. Гамшигтай тэмцэх асуудал нь дэлхийн улс орнуудын энэ тэргүүний асуудал бөгөөд гамшигтай тэмцэх чадавх сайжирсанаар улс орны тогтвортой хөгжих үндэслэлийн нэг гэж ойлгож байна. Эхний төслийн үр өгөөж гарч үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулж эрдэнэт хүний амь насыг аварч эмнэлэгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн, Дархан-Уул аймагт

	гарсан нефтийн агуулахад гарсан гал түймрийг унтраасан зэрэг асуудлууд болон тоон үзүүлэлтүүдээс тодорхой харагдаж байна. Цаашид улс орон, техник технологи хөгжих болон байгаль, цаг уурын өөрчлөлтийн хэрээр гамшиг, гал түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаа нь бидэнд байнгын бэлэн байдал дэлхийн улсуудад ашигладаг өндөр хүчин чадалтай техник, тоног төхөөрөмж шаардлагатай билээ. 2. Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, улс орны нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ихтэй тул боломж бололцоо нь байдаг бол зөвхөн нисдэг тэрэг, гал унтраах автомашин, зарлан мэдээлэл, агуулах зэргээр тогтохгүй сургалт, технологи өмнө төслөөр нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын асуудлыг тусгах шаардлагатай гэж бодож байна. Төсөл хэрэгжихээр бол техникийн мэргэжлийн байгууллагуудын инженер техникийн мэргэжилтэн нарыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж санал авах Монгол улсын Онцгой байдлын албанд нэн хэрэгцээтэй байсан нисдэг тэрлийг Бүгд найрамдах Франц улсад үйлдвэрлэсэн нисдэг тэрэгээр шийдэж өгсөнөөр албаны бэлтгэл бэлэн байдал сайжирсан төдийгүй мөн шинээр орж ирсэн автомашинууд Монгол улсын эрс тэс уур амьсгалд тохиромжтой хэрэглэхэд ойлгомжтой байсанаараа давуу талтай байна. Цаашид уг төслүүдийг үргэлжлүүлэн техник хэрэгсэлтэй харьцах, албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэн хөгжүүлэхэд онцгой анхаарч ажиллана гэдэгт итгэлтэй байна. Танай төсөл их таалагдаж байгаа. Энэхүү төслөө цаашид улам өргөжүүлж боловсон хүчнээ илүү сайн бэлдэх хэрэгтэй. Ялангуяа гадагшаа явуулж сургаад олон улсын гэрчилгээтэй болгоод цаашид туршлагатай боловсон хүчнээрээ Монголдоо шинэ боловсон хүчнээ бэлддэг болох хэрэгтэй. Уг төслийг дэмжиж бна цаашид үргэлжлүүлэхийг хүсэж бна
16	Ч.Шийлэгбат, chimeddorj22@gmail.com
17	Ө.Энхбаатар, ulpo038@icloud.com
18	Атартуяа, atgaa8989@gmail.com
19	И.Өнөрхзул, suuuunuuu@gmail.com
20	Б.Ганбаяр, ganaa950829@gmail.com
21	Цогоо, tsogjavhlan0609@gmail.com
22	А.Батмөнх, ba.altanzul6626@gmail.com

Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн энэ төсөл хэрэгжиж байгаа нь үнэхээр өгөөжтэй төсөл гэж бодож байна. Ард иргэдэд хүртээмжтэй.

23	Энхээ, enkushina@gmail.com	Хүний амь насыг авран хамгаалж, байгаа энэ төсөл бол Монгол Улсад хэрэгжиж байгаа хамгийн бодитой, нийгэмд хэрэгцээтэй буянтай төсөл шүү.
24	Батсүмбэр, batsumberd6@gmail.com	Монгол Франц хоёр улсын засгийн хэлэлцээрээр хэрэгжиж буй агаараас эрэн хайх, аврах нисэх нэгж байгуулах төсөл нь Монгол хүний юугаар ч үнэлэшгүй алтан амийг аврахад маш том хөрөнгө оруулалт болсон төсөл гэж бодож байна. Аврал эрсэн хэн бүхний амь нас, эрүүл мэнд нь минут секундээр хэмжигдэд тул манайх шиг өргөн уудам газар нутагтай улсад яг тохирох нь нисдэг тэрэгтэй аврах ажиллагаа юм
25	Д.Болорцэцэг, peta.bolor@gmail.com	Энэ төсөл нь олон хүний амь насыг аварсан, ард иргэдэд хэрэгтэй, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай төсөл гэдэг нь эхний шатны төслийн үр дүнгээс харагдаж байна.
26	Ирмүүн, mirmuun@yahoo.com	Онцгой байдлын албанд нисэх нэгж байгуулсан нь маш үр дүнтэй ажил болсон. Цаашид үргэлжлүүлэх шаардлагатай
27	Бат-Өлзий, batuka0725@gmail.com	Агаараас эрэн хайх, аврах ангийг чадавхжуулах төслийн хувьд аймаг тус бүрд буух талбай, ажиллах боловсон хүчин бэлтгэж бэлтгэл бэлэн байдлыг хангах аймаг тус бүрт агаараас эрэн хайх, аврах ангийг нэмэгдүүлэн байршуулвал алсдаа эрсдсэн, нэрвэгдэгчийг цаг алдалгүй ГССҮТ-д хүргэх, Автомеханик шатны хэрэгцээ маш их байдаг, учир юу вэ гэвэл жишээ нь аймаг тус бүрд 2-оос доошгүй байдаг, одоо цаг үед 10 болон түүнээс дээш давхар барилгууд аймаг тус бүрд 20-30% хувийг эзэлж байгаа иймд автомеханик шатны тоог нэмэгдүүлэх, хүнсний агуулах барих төслийн хувьд Ковид-19 цар тахал нь маш том шалгуур болж өгсөн, үүний үр дүнд энэ тэндгүй хямрал, үнийн хөөрөгдөл цаашдаа ямар нэгэн вирус, цар тахал, гамшигт үзэгдэл болсон тохиолдолд хүнсний нөөцийн агуулахтай, нөөцтэй байвал даван туулхад ашиг тус үзүүлэх байгаа гэсэн саналуудтай байна
28	Энхбаяр, enxee987@gmail.com	Энэ төслийн үр шимээр Говь-Алтай аймгийн хувьд гал унтраах чадамж эрс дээшилсэн. Орчин үеийн техник ашиглана гэдэг дагаад алба хаагчдын ур чадвар нэмэгдэнэ гэсэн үг. Тийм учраас цаашид төсөл хөтөлбөр үргэжиллэхийг дэмжиж байна.

№	Байгууллага, иргэн	Санал
1	DOS ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Батмөнх	Агаараас эрэн хайх, аврах ангийг (Ховд) аймагт байгуулах
		Нисгэгч, тусгай зориулалтын автомашины механикчдийн цалин хангамж, сүлжээг нэмэгдүүлэх тогтвор сууршилттай байлгах
2	Ойн газар Б.Аманжол	Агаараас аврах анги хүн болгоны өгсөн дуудлагад хүрч очих боломжтой болох, нисэх зардал шийдвэрлэх
3	Иргэн (нэрээ ирүүлээгүй.)	Агаараас эрэн хайх, аврах анги шиг техникийн инженерийг тухайн тусгай зориулалтын автомашин үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчээс авч ирж заалгах
4	Иргэн Ц.Болор-Эрдэнэ	111-р ангийн захирагч, хурандаа Т.Мөнхдорж иргэдэд үйлчилсэн үйлчилгээний зардал хэрхэн төлөгддөг талаар тодорхой журам гаргах
5	Иргэн Чимэдцэрэн	ОББ-ын Агаараас эрэн хайх аврах 111-р ангийн төслийн 2-р үе шатны танилцуулга. -Төхник, техникийн чадавх -Дэд бүтцийн чадавх - Хүний нөөцийн чадавх - Эрх зүйн тогтолцооны чадавхийг анхаарах. Санал: Амжилттай хэрэгжүүлж байгаад маш их талархаж байна. Эрх зүйн тогтолцоог бүлдүүлсэн байдалд шинжилгээ хийхэд анхаарах саналтай байна.
6	ГУТОТС-ын холбооны ерөнхийлөгч Я.Ишжамц	Агаараас эрэн хайх, аврах ангийг сайн бэхжүүлж, салбар анги нэгжийг баруун бүс, хойд бүс, зүүн бүс, өмнөд бүсэд гэх мэтээр байгуулах шаардлагатай.



Гамшгийн эрсдэлгүй амьдралын төлөө

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг

8 дугаар хороо 26 хэрэгүүсийн газрын 20 тал

Байрны нөхцөл байдал дүрэм 204 тал

Утас: 99.80004, 99.73010

И-мэйл: gamshig@fire.mn

2023.09.16 № 23/184
Тэмдэг -ны НБ

"ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР-1"

/ Хамтран ажиллах тухай /

Монгол улсын Засгийн газар, Бүгд найрамдах Франц улсын Засгийн газрын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд БНФУ-ын Иргэний аюулгүй байдал, гамшгийн удирдлагын газартай хамтран агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах төслийг амжилттай хэрэгжүүлсэнээр Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги байгуулагдаж, хоол гаруйн өмнөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба энэ хугацаанд 120 гаруй хүний алтан амийг ой, хээрийн түймэр, бусад аюулт үзэгдлийн голомтоос аварч тэр хэмжээний айл өрх элэг бүтэн үлдсэнд талархаж байна.

Манай улсад ой, хээрийн түймэр их тохиолддог бөгөөд түймрийн голомтод болсно хугацаанд хүрэлцэн очих, хүн хүч хэрэгслийг тээвэрлэн хүргэх, бөглөх хэрэгсэл, хоол хүнсээр хангахад бөглөх оврын нэгдэл тэрэг ашиглах нь онсөнгөй шийдэл юм.

Манай "Гамшгийн эрсдэлгүй амьдралын төлөө" нийгэмд үйлчилдэг тэрийн бус байгууллага нь гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, зөвлөх үйлчилгээ, гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд 2020 оноос эхлэн Онцгой байдлын ерөнхий газартай гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллах санааж бичиг байгуулан ажиллаж байна.

Гамшигтай тэмцэх хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисгэгч сургаж бэлтгэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгааг дэмжиж, цаашид хамтран ажиллахад бэлэн байгааг илэрхийлнэ. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хүндэтгэсэн: Гамшгийн эрсдэлгүй амьдралын төлөө

ТББ-ын тэргүүн

Б.Батболд



АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН НЭРС

№	Нэр	Албан тушаал	Гар утас
1	Б.Жавхлан	Сангийн сайд	-
2	Г.Ариунбуян	Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал	99296458
3	Б.Сүх-Очир	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	99011664
4	Л.Өлзийбаяр	Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа	99105574
5	Ц.Нямбаяр	Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа	88093652
6	Б.Мөнх-Оргил	Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга	99103869
7	Л.Соноор	Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга	99066188
8	Б.Бямба-Эрдэнэ	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн	99184949